

Хорт хий

2023 оны 3-р сар



Зураг 1. Бортого унаж хлорын хий алдагдсан

Эх сурвалж: <https://www.voanews.com/a/jordan-negligence-responsible-for-aqaba-chlorine-tank-explosion-/6644453.html>

Юу болсон?

2022 оны 6-р сарын 27-ны өдөр Иорданы Акаба хотод 25 тонн шингэрүүлсэн хлорын хий бүхий савыг усан онгоц дээр кранаар өргөн ачиж байв.

Өргөлтийн кабел тасарч, усан онгоцны тавцанг сав цохиж задарсан байна. Хортой хлорын хий бүхий маш том хэмжээний үүл бий болж хүмүүсийг нүүлгэн шилжүүлсэн. 13 хүн нас барж 300 гаруй хүн эмнэлэгт хүргэгдэн тусламж авсан байна.

Албаны хүмүүсийн мэдээлж буйгаар уг савны жин нь өргөлтийн кабелны даацаас 3 дахин их байсан ба аюултай бодистой харицах аюулгүй ажиллааны шаардлагатай арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Тухайн үед тавцан дээр өргөх хэрэгсэл, горимыг шалгах мэргэшсэн хүн байгаагүй аж.

Мэргэжилтнүүдийн хэлж буйгаар асгаралт болохоос өмнө олон тооны ажилчид ээлжнээс буугаад талбайгаас явж амжаагүй байсан тул уг осол гамшгийн үр дагаварт хүргэж болох байжээ. Азаар хотын хүн ам сууришсан хэсгийн эсрэг талруу цөлийн чиглэлд хортой хийг салхи үлээсэн байна.

Химийн бодисын хатуу, шингэн, хийн төлөв байдлын алдагдалаас үл хамааран буулгалт хийхдээ анхаарал тавих хэрэгтэй. Энэ тохиолдолд л гэхэд осол болох үед ачилтын талбайд ойр, тэнд байх шаардлагагүй олон тооны хүмүүс байсан байна.

Та мэдэх үү?

- Хортой хий нь хүний биед хүрэхэд харицангүй бага хортой нөлөө үзүүлдэг.
- Хорт хийг ихэвчлэн хлор, аммиак зэрэг цочроогч, азот, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг амьсгал боогдуулагч, азотын исэл зэрэг мэдээ алдуулагч, хүхэрт устөрөгч, цианид зэрэг тусгай хортой бодис гэж ангилдаг.
- Уушиг нь цусны урсгалтай холбогддог тул хорт хийгээр амьсгалах нь маш хурдан үхэлд хүргэдэг. Зарим материал нь арьс нүдээр дамжин биед ордог.
- Хорт хий нь ихэвчлэн даралттай саванд хадгалагдаж, тээвэрлэгддэг тул онцгой аюултай. Хий алдагдсан үед агаарт хурдан тархдаг. Устөрөгчийн сульфид, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг нь өнгө үнэргүй байдаг.
- Өргөлтийн ажил аюултай. Зарим улс орон, компаниуд өргөлтийн албан ёсны төлөвлөгөөг шаарддаг. Химийн өндөр аюултай материал бүхий газарт хүнд өргөлт хийх аюулгүй ажиллагааны дадал, мөн өргөлтийн төлөвлөгөөний үндсэн элемент зэргийг дараагийн анхааруулга дээр оруулах болно.

Та юу хийж болох вэ?

- Хортой хий бүхий материалтай харицах бэлтгэл хийхдээ хэрэв хий алдагдвал юу хийх талаар үргэлж оруулж байх хэрэгтэй:
 - ✓ Харицаж буй материал, тоног төхөөрөмж, орчин тойрондоо үргэлж анхааралтай бай
 - ✓ Хортой хий хадгалагдаж, ашиглагдаж буй газарт анхааруулах санамжууд, тэмдэг, шошго зэргийн уншиж байх
 - ✓ Өргөлтийн ажлын үед талбайгаас хол байж, ойр байгаа хүмүүст анхааруулах
 - ✓ Хэрэв химийн бодис алдагдвал хаашаа гарах, ямар журам мөрдөх өө мэддэг байх
 - ✓ Онцгой үед хариу үзүүлэхээр сургагдаж, тоног төхөөрөмжөөр хангагдаагүй л бол хорт хий алдагдсан үед тэмцэх хэрэггүй, шууд холд. Хорт хий алдагдаж буй замаас хол, салхины урсгалыг хөндлөн байдлаар гарч аюулгүй газар, хоргодох байр руу оч.
 - ✓ Хий алдагдсан үед тохиромжтой, зөвшөөрөгдсөн зөөврийн хий мэдрэгч, бусад хувийн хамгаалах хэрэгсэл, өөртөө тохируулсан амьсгал хамгаалах баг зэргийг ашигла.

Хорт хийнд өртөх нь үхлийн аюултай байж болно. Өөрийгөө болон бусдыг хамгаалах арга хэмжээ аваарай.